



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/87/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баруун-Урт 2022 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	12
3.8 Аудитын гол асуудал .....	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт .....	13
4.1 Төлбөрийн акт.....	13
4.1 Зөвлөмж .....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1. Аудитын санал дүгнэлт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.02.25 № 32  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
С.БАТЧУЛУУН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын хоёрдугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>101,761,067.90</b>	<b>100,989,475.33</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	9,415,622.74	9,177,814.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,690,875.99	6,453,067.47
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	2,724,746.75	2,724,746.75
3351	Байгууллагаас авах авлага	2,724,746.75	2,724,746.75
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	92,345,445.16	91,811,661.11
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	711,920.00	1,008,550.00
35130	Эм боох материал	711,920.00	1,008,550.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	12,278,555.20	12,278,555.20
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	79,354,969.96	78,524,555.91
35410	Бичиг хэргийн материал	621,600.00	1,855,637.00
35420	Аж ахуйн материал	1,641,870.00	2,373,988.00
35450	Барилгын засварын материал	1,802,960.00	2,350,060.00
35460	Хүнсний материал	2,335,970.00	210,540.01
35470	Бусад хангамжийн материал	72,952,569.96	71,734,330.90
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,264,167,342.38</b>	<b>1,201,890,004.09</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,264,167,342.38	1,201,890,004.09
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,026,303,342.38	964,026,004.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	971,377,500.00	971,377,500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-70,563,404.40	-105,845,106.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	144,838,123.32	152,374,813.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	-132,066,710.23	-132,329,146.24
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	104,521,668.20	117,352,107.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-75,307,271.03	-81,440,871.33
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,434,400.00	22,434,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-12,084,353.17	-16,563,193.61
39217	Ном	73,153,389.69	36,665,500.99
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	237,864,000.00	237,864,000.00
39301	Програм хангамж	2,697,150.00	2,697,150.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,697,150.00	-2,697,150.00
39303	Бусад биет бус хөрөнгө	237,864,000.00	237,864,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,365,928,410.28</b>	<b>1,302,879,479.42</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,365,928,410.28</b>	<b>1,302,879,479.42</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,365,928,410.28	1,302,879,479.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,272,763,877.57	1,272,763,877.57
51101	Өмч: - төрийн	1,272,763,877.57	1,272,763,877.57
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-310,734,126.16	-373,783,057.02
51210	Өмнөх үеийн үр дүн	-310,734,126.16	-319,760,972.16
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	-54,022,084.86
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	403,898,658.87	403,898,658.87
<b>6</b>	<b>ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,365,928,410.28</b>	<b>1,302,879,479.42</b>

**Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,596,082,847.31</b>	<b>1,579,159,091.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,535,447.31</b>	<b>14,859,213.60</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,535,447.31	14,859,213.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,535,447.31	14,859,213.60
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,535,447.31	14,859,213.60
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>215,252,000.00</b>	<b>234,884,078.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,351,295,400.00	1,329,415,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	5,365,778.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	905,778.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,660,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	215,252,000.00	229,518,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,252,000.00	229,518,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,600,234,704.75</b>	<b>1,592,873,492.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,600,234,704.75</b>	<b>1,592,873,492.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,536,490,226.83	1,545,270,755.77
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,097,567,388.78	1,072,491,682.49
210101	Үндсэн цалин	694,881,738.79	670,297,102.06
210102	Нэмэгдэл	294,579,990.65	319,340,963.12
210104	Урамшуулал	108,105,659.34	82,853,617.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	135,414,911.23	141,130,538.33
210201	Тэтгэврийн даатгал	95,093,298.52	102,676,638.33
210202	Тэтгэмжийн даатгал	10,100,629.22	9,613,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,405,583.45	7,690,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,687,636.36	1,922,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,127,763.68	19,226,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	205,836,502.00	224,518,300.00
210301	Гэрэл, цахилгаан	5,528,204.36	6,276,534.10
210302	Тулш, халаалт	190,116,850.00	203,440,665.90
210303	Цэвэр, бохир ус	10,191,447.64	14,801,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,071,890.00	6,337,648.00
210401	Бичиг хэрэг	2,818,450.00	1,804,382.00
210402	Тээвэр, шатахуун	4,499,100.00	606,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,440,680.00	894,200.00
210404	Ном, хэвлэл	478,900.00	21,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	70,300.00	523,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,764,460.00	2,487,666.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,391,360.00	3,951,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	3,804,930.00	1,711,150.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	586,430.00	2,239,910.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,421,820.00	30,570,080.00
210604	Урсгал засвар	16,421,820.00	30,570,080.00
<b>2107</b>	<b>Томилголт, зочны зардал</b>	553,900.00	550,300.00
210702	Дотоод албан томилголт	553,900.00	550,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,560,000.00	495,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,560,000.00	495,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	62,672,454.82	65,225,846.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,869,150.00	14,207,268.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	50,803,304.82	51,018,578.95
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	63,744,477.92	47,602,736.69
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	33,802,780.00	43,037,789.49
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,662,100.00	3,106,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,140,680.00	39,931,789.49
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	29,941,697.92	4,564,947.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,941,697.92	4,564,947.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-4,151,857.44</b>	<b>-13,714,400.86</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	40,307,684.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	40,307,684.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-40,307,684.00
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-4,151,857.44</b>	<b>-54,022,084.86</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,272,763,877.57	415,353,444.05	-318,037,053.90	00.00	1,370,080,267.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,272,763,877.57	415,353,444.05	-318,037,053.90	00.00	1,370,080,267.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-4,151,857.44	00.00	-4,151,857.44
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,272,763,877.57	403,898,658.87	-310,734,126.16	00.00	1,365,928,410.28
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,272,763,877.57	403,898,658.87	-310,734,126.16	00.00	1,365,928,410.28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-9,026,846.00	00.00	-9,026,846.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,272,763,877.57	403,898,658.87	-319,760,972.16	00.00	1,356,901,564.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-54,022,084.86	00.00	-54,022,084.86
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,272,763,877.57	403,898,658.87	-373,783,057.02	00.00	1,302,879,479.42

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,570,461,200.00</b>	<b>1,564,299,878.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,913,800.00</b>	<b>00.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,913,800.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,913,800.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,913,800.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,566,547,400.00</b>	<b>1,564,299,878.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,351,295,400.00	1,329,415,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	5,365,778.00
131103	ЗГНХ,ЗДНХ хөрөнгө, гүүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	905,778.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	3,660,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	215,252,000.00	229,518,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	215,252,000.00	229,518,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,567,661,200.00</b>	<b>1,546,812,548.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,567,661,200.00</b>	<b>1,546,812,548.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,501,280,752.08</b>	<b>1,498,730,411.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,107,017,140.86	1,079,470,388.30
210101	Үндсэн цалин	704,331,490.87	677,275,807.87
210102	Нэмэгдэл	294,579,990.65	319,340,963.12
210104	Урамшуулал	108,105,659.34	82,853,617.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	135,414,911.22	140,631,800.00
210201	Тэтгэврийн даатгал	95,093,298.52	102,177,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,100,629.21	9,613,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,405,583.45	7,690,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,687,636.36	1,922,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,127,763.68	19,226,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	210,252,000.00	224,518,300.00
210301	Гэрэл, цахилгаан	5,528,204.36	6,276,534.10
210302	Түлш, халаалт	190,116,500.00	203,440,665.90
210303	Цэвэр, бохир ус	14,607,295.64	14,801,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	17,319,400.00	11,986,800.00
210401	Бичиг хэрэг	2,301,700.00	2,612,200.00
210402	Тээвэр, шатахуун	4,459,100.00	606,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,785,900.00	894,200.00
210404	Ном, хэвлэл	4,313,800.00	660,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн усгал, ариутгал	403,300.00	495,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх ахуйн эд зүйлс	3,055,600.00	6,718,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	6,696,900.00	3,330,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,635,100.00	1,183,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,061,800.00	2,146,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,780,000.00	24,922,975.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,780,000.00	00.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	24,922,975.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	553,900.00	550,300.00
210702	Дотоод албан томилолт	553,900.00	550,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,752,000.00	780,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,752,000.00	780,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	12,494,500.00	12,538,948.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,494,500.00	12,538,948.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>66,380,447.92</b>	<b>48,082,136.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	36,438,750.00	43,517,189.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,962,100.00	3,113,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,476,650.00	40,404,089.50
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	29,941,697.92	4,564,947.20
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,941,697.92	4,564,947.20
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>2,800,000.00</b>	<b>17,487,330.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>2,800,000.00</b>	<b>17,487,330.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,800,000.00</b>	<b>17,487,330.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үсвэрээр</b>	2,800,000.00	17,487,330.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,800,000.00	17,487,330.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-2,800,000.00</b>	<b>-17,487,330.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,558,934,100.00	1,554,458,752.80
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,558,934,100.00	1,554,458,752.80
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,515,254,200.00	1,510,941,563.30
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,083,734,000.00	1,079,470,388.30
210101	Үндсэн цалин	681,539,300.00	677,275,807.87
210102	Нэмэгдэл	319,341,000.00	319,340,963.12
210104	Урамшуулал	82,853,700.00	82,853,617.31
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	140,631,800.00	140,631,800.00
210201	Тэтгэврийн даатгал	102,177,900.00	102,177,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,613,600.00	9,613,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,690,800.00	7,690,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,922,600.00	1,922,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,226,900.00	19,226,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	224,518,300.00	224,518,300.00
210301	Гэрэл, цахилгаан	6,276,534.10	6,276,534.10
210302	Түлш, халаалт	203,440,665.90	203,440,665.90
210303	Цэвэр, бохир ус	14,801,100.00	14,801,100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,007,600.00	13,007,600.00
210401	Бичиг хэрэг	2,876,200.00	2,876,200.00
210402	Тээвэр, шатахуун	606,400.00	606,400.00
210403	Шуудан, холбоо, ингэрнэгийн төлбөр	1,651,000.00	1,651,000.00
210404	Ном, хэвлэл	660,400.00	660,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	495,300.00	495,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,718,300.00	6,718,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	3,330,200.00	3,330,200.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,183,500.00	1,183,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,146,700.00	2,146,700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	29,700,000.00	29,650,975.00
210604	Урсгал засвар	29,700,000.00	29,650,975.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	550,300.00	550,300.00
210702	Дотоод албан томилолт	550,300.00	550,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	495,300.00	495,300.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	495,300.00	495,300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	19286700.00	19286700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,286,700.00	19,286,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	43679900.00	43517189.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	43,679,900.00	43,517,189.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,113,100.00	3,113,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,566,800.00	40,404,089.50
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,558,934,100.00	1,554,458,752.80
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,329,415,800.00	1,324,940,452.80
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,329,415,800.00	1,324,940,452.80
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	229,518,300.00	229,518,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	229,518,300.00	229,518,300.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	79.00	79.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	52.00	52.00
620003	Үйлчлэх ажилтан	26.00	26.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>5,276,178.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,276,178.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		5,276,178.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		285,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		285,400.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.00	4,990,778.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		4,990,778.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	0.00	5,276,178.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		5,276,178.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		905,778.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		3,570,400.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд үндсэн хөрөнгө, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль нь “Хүүхэд бүрийг ойлгодог, Ёс зүйгээрээ үлгэрлэдэг, Шинийг эрэлхийлэгч, бүтээгч, Тасралтгүй суралцдаг” гэсэн эрхэм зорилготой байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,600.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 16.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 63.0 сая төгрөгөөр буюу 5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	9.4	9.2	-0.2
Бараа материал	92.3	91.8	-0.5
Үндсэн хөрөнгө	1,264.2	1,201.9	-62.3
Нийт хөрөнгө	<b>1,365.9</b>	<b>1,302.9</b>	<b>-63.0</b>
Өр төлбөр	-	-	-

<b>Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/</b>	<b>1,365.9</b>	<b>1,302.9</b>	<b>-63.0</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,365.9</b>	<b>1,302.9</b>	<b>-63.0</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,201.9 сая төгрөг болж 62.3 сая төгрөгөөр буурсан аймгийн ИТХ-ын 2021 оны 03 дүгээр тогтоолоор 45.2 сая төгрөгийн ном, тоног төхөөрөмж акталж, элэгдлийн зардлаар хөрөнгө буурсан нь нөлөөлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,302.9 сая төгрөг болж 63.0 сая төгрөгөөр буурсан байна.

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 17.0 сая төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна. Тодруулбал үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 14.7 сая төгрөгөөр буурч, тайлант үед 14.5 сая төгрөг болж буурсан нь үр дүнгийн тайлангийн орлого буурахад голлон нөлөөлсөн байна.

Нийт зардал өмнөх оноос 7.3 сая төгрөгөөр буюу 0.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, тээвэр шатахуун зэрэг зардлууд байна. Энэ нь ковид-19 цар тахлын хүрээнд сургуулийн үйл ажиллагааг зогсоосон, засгийн газрын 2021 оны 43 дүгээр тогтоолын дагуу төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлсэнтэй нь холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,601.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,601.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 43.0 сая төгрөгөөр бууруулж 1,558.9 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2021 онд ковид-19 гарсантай холбогдуулан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин, сургуулийн үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан хоолны зардлыг бууруулж, төсөвт тодотгол хийсэн нь нөлөөлсөн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,558.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,554.4 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 4.5 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт зардлын 1,324.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 229.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 0.8 сая, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 0.9 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 3.6 сая, нийт 5.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 0.3 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 5.0 сая, нийт 5.3 сая төгрөгийг зарцуулжээ.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Тайлант онд Баруун-Урт сумын Засаг даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээнд зарцуулсан төсвийн гүйцэтгэл 91.2 хувийн биелэлттэй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 146 мэдээлэл, хугацаа хоцорч 1 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолоор төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн 9 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан байна. Тухайлбал:

- Тогтоолын 1.1-д “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”
- Тогтоолын 1.8-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах; гэж заасан байна”

Сангийн яамнаас 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Тодруулга хүргүүлэх тухай” Н-3/845 дугаар албан бичгийг Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна. Тус албан бичигт “Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д заасан “үндсэн үйл ажиллагаатай холбоотой зайлшгүй шаардлагатай зардал, төсөл, арга хэмжээ” гэдэгт төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор ажилтан, албан хаагчдад төлж байгаа цалин хөлс, олговор, ажил олгогчоос төлөх нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, цахилгаан, халаалт, цэвэр, бохир ус, түрээсийн зардал болон байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбоотой шаардлагатай бусад зардал хамаарна.” гэж тодруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 13.1 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгч бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	13.1	3	13.1	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-	-	-
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	4	13.1	4	13.1	-	-	-

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 6.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2 асуудалд зөвлөмж өгсөн.

### 4.1 Төлбөрийн акт

Төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төсөвт төвлөрүүлээгүй 6.4 сая төгрөгийн бодит бус авлага үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1/Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 6.4.8 /төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 7 дугаар зүйлийн 7.7 /Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ./, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, 45 дугаар зүйлийн 45.2 /Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ:/ дахь заалт болон оршин байх, эрх ба үүрэг, иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

#### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 94 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

##### **2. Түлш халаалтын зардалтай холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулаагүй нь Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолын 1 дэх “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төсөвт байгууллагын дулааны эрчим хүчний хэрэглээг хэмжүүрээр тооцох нөхцөлийг бүрдүүлж, тоолуур суурилуулах ажлыг 2020 оны 3-р улиралд багтаан зохион байгуулж, хэрэгжүүлэхийг төсвийн захирагч, гүйцэтгэх удирдлага нарт үүрэг болгосугай” заалттай нийцэхгүй байна.

###### **2.1. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын барилгад дулааны тоолуур суурилуулж, дулааны эрчим хүчний төлбөрийг Эрчим хүчний зохицуулах хорооны 2021 оны 10 сарын 14-ний өдрийн 461 дүгээр тогтоолоор батлагдсан “Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф”-ыг мөрдөж, Засгийн газрын 2020 оны 144 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	3	6.4	-	-	1	6.4	-	-	2	-